



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/824

Улаанбаатар хот

Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн  
хөгжлийн газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/423 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газар татан буугдсан тул эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 40,998,000.00 (дөчин сая есөн зуун ерэн найман мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын балансад шилжүүлж данс бүртгэлээс хасахыг Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар (А.Мөнгөн)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлан бодогч (Ж.Оюунмаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюунмаа* В.ОЮУМАА



1150500801

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны 06 сарын 30-ны дугаар сарын 30-ны өдрийн  
06 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон но	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	/Төгрөгөөр/	
									Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>Машин, тоног төхөөрөмж</b>										
1	Процессор Dell i5 3090MT	2022	ш	2	2,399,000.0	4,798,000.0	2,398,999.98	2,399,000.02	Нийслэлийн Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар	
2	Дэлгэц Dell 27inch LED	2022	ш	2	1,599,000.0	3,198,000.0	1,599,000.00	1,599,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
4	Принтер HP LaserJet	2022	ш	1	699,000.0	699,000.0	466,000.08	232,999.92	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
5	Онлайн хурлын төхөөрөмж Cisco telepresen	2023	ш	1	10,835,000.0	10,835,000.0	2,934,479.21	7,900,520.79	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
	Машин, тоног төхөөрөмжийн дүн			6	15,532,000.0	19,530,000.0	7,398,479.3	12,131,520.7	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
<b>Тавилга, эд хогшил</b>										
1	Сэтгүүлийн ширээ модон шар	2022	ш	1	450,000.0	450,000.0	90,000.0	360,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
2	Албан хаагчдын ширээ 6 хүний	2022	ш	1	2,354,000.0	2,354,000.0	470,800.1	1,883,199.92	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
3	Албан хаагчдын ширээ 4 хүний	2022	ш	2	1,890,000.0	3,780,000.0	756,000.0	3,024,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
4	Албан хаагчдын ширээ 2 хүний	2022	ш	1	1,260,000.0	1,260,000.0	252,000.0	1,008,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
5	Цайны ширээ сандал иж бүрэн	2022	ш	1	1,850,000.0	1,850,000.0	370,000.1	1,479,999.92	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
6	Хэлтсийн даргын ширээ модон цайвар	2022	ш	2	1,200,000.0	2,400,000.0	480,000.0	1,920,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	
7	Хурлын ширээ модон цагаан алга өнгөтэй	2022	ш	1	1,850,000.0	1,850,000.0	370,000.1	1,479,999.92	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	

8	Албан хаагчдын сандал дуулайтай цайвар цэнхэр	2022	ш	19	396,000.0	7,524,000.0	3,009,600.0	4,514,400.00	
	Тавилга, эд хогшиллын дүн			28	11,250,000.0	21,468,000.0	5,798,400.2	15,669,599.8	
	Нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлэх хөрөнгийн дүн			34	26,782,000.00	40,998,000.00	13,196,879.51	27,801,120.49	